

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ИТХ-ЫН 2023 ОНЫ **НӨХӨН** БОЛОН
ДАХИН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

ДҮГНЭЛТ: ОРОН НУТГИЙН ИТХ-ЫН НӨХӨН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ
ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

2023

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НӨХӨН, ДАХИН СОНГУУЛЬ



АУДИТЫН КОД: СЭА-2023/53-12-ШТА-ГА

ОРОН НУТГИЙН ИТХ-ЫН 2023 ОНЫ НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛЬ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Сүхбаатар сум 2023 он



Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа

Утас: 70363040, Цахим хаяг:

Enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036, Цахим хаяг:

Batmunkhb@audit.gov.mn

Аудитор Т.Одсүрэн

Цахим хаяг: Odsurent@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой

 Аудитыг гүйцэтгэсэн: Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа Аудитын менежер Б.Батмөнх Аудитор Т.Одсүрэн Хаяг: Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд 2023 оны 07 дугаар сар	АГУУЛГА Товчилсон үгийн тайлбар АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ОРОН НУТГИЙН ИТХ-ЫН НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛИЙН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ СУМДЫН СОНГУУЛИЙН ХЭСГИЙН ХОРООДОД ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН УУ? 1.1 Улсын төсвөөс санхүүжүүлсэн орон нутгийн ИТХ-ын нөхөн болон дахин сонгуулийн зардлыг СЕХ-оос аймгийн Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэст хуваарийн дагуу бүрэн олгосон уу? 1.2 Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын Сонгуулийн хороодын зардлыг үндэслэлтэй төлөвлөж хуваарилсан уу? ХОЁРДУГААР БҮЛЭГ: ОРОН НУТГИЙН ИТХ-ЫН НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ҮР АШИГТАЙ, ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН УУ? 2.1 Аймаг, сумын Сонгуулийн хороод хуваарилагдсан санхүүжилтийг зориулалтын дагуу, үр ашигтай хэмнэлттэй зарцуулсан уу? 2.2 Сонгуулийн зардлын зарцуулалт, гүйцэтгэлийг бодитой тайлагнасан уу? ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ
--	---

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МТБ	Мэдээлэл технологийн баг
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СЭА	Сэлэнгэ аймаг
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
УИХ	Улсын Их Хурал
ШТА	Шууд тайлагнах аудит

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын нэр:

Орон нутгийн ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийх аудит

Аудитын код:

СЭА-2023/53-12-ШТА-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8, 10.11, хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/61 дугаарын хавсралтаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөнд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хуульд заасны дагуу хийгдэх аудитыг тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Орон нутгийн ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэв.

Үүнд:

- Орон нутгийн ИТХ-ын нөхөн болон дахин сонгуулийн зардлын төлөвлөлт, улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг үндэслэлтэй хуваарилсан уу?
- Орон нутгийн ИТХ-ын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг үр ашигтай хэмнэлттэй зарцуулсан уу?

Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймаг, сумдын Сонгуулийн хороод, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг байгууллагуудыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн гаргасан Монгол Улсын Төрийн аудитын стандарт / MNS:6817-1:2020 “Төрийн аудит.Тулгуур зарчим”, MNS:6817-5:2020 “Төрийн аудит.Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит.Гүйцэтгэлийн аудит”-д заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106

дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан шалгагдагч болон хамрагдагч байгууллагын сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулж, асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага, дүн шинжилгээ хийх, аудитын асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулав.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль;
- СЕХ-ны 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих, журам”
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тогтоол;
- СЕХ-ны Ажлын албаны баталсан төсвийн хуваарь;
- Холбогдох бусад хууль эрхийн актууд зэрэг болно.

Аудитын хугацаа:

Аудитыг 2023 оны 06 дугаар сарын 19-нөөс 07 дугаар сарын 17-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэн Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн, аудитор Т.Одсүрэн гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлан, 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9-д заасны дагуу Баруунбүрэн, Сүхбаатар сумдад сумын ИТХ-ын нөхөн сонгуулийг 2023 оны 06 дугаар сарын 18-ны өдөр явуулах шийдвэрийг СЕХ-ноос гаргасан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтын дагуу аймгийн ИТХ-ын 2022 оны 03-р сарын 03-ны өдрийн 28 дугаар тогтоолоор аймгийн Сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан ажлын хэсгийг татан буулгаагүй байсан тул 2023 оны нөхөн сонгуулийн хорооны гишүүдээр үргэлжлүүлэн ажиллуулсан байна.

Аймгийн Сонгуулийн хороонд 9 /баталсан 7 ажилтан болон аймгийн сонгуулийн хорооны захирамжаар ажиллуулсан нягтлан бодогч, нярав/, сумдын салбар хороонд 10, хэсгийн хороодод 21, мэдээллийн технологийн 6 даамал, улсын бүртгэлийн ажилтан 3, цагдаагийн байгууллагын 6 зэрэг нийт 55 төрийн албан хаагч ажилласан байна.

Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 13.3 дахь заалт болон хүн амын нягтаршил, газар зүйн байршлыг харгалзан 2 сумын 3 хэсэгт хороог зохион байгуулсан байна.

СЕХ-ноос аймгийн Сонгуулийн хороонд нөхөн сонгуулийн нийт санхүүжилтэд **47,301.0** мянган төгрөгийг төлөвлөж, хуваарилсан санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Сонгогчдын нэрсийн жагсаалт хэвлэх, санал авах техник хэрэгслийг тээвэрлэх болон түүнтэй холбогдсон албан хаагчийн сургалт зохион байгуулах болон мөнгөн урамшуулал, унаа, хоолны зардалд нийт **6,714.0** мянган төгрөгийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас аймгийн УБХ-т хуваарилсан байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛИЙН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ СУМДЫН СОНГУУЛИЙН ХЭСГИЙН ХОРООДОД ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН УУ?

Орон нутгийн нөхөн болон дахин сонгуулийн зардлыг холбогдох хууль, эрхийн актын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

1.1 Улсын төсвөөс санхүүжүүлсэн орон нутгийн нөхөн болон дахин сонгуулийн зардлыг СЕХ-оос аймгийн Сонгуулийн хороо, УБХ-д хуваарийн дагуу бүрэн олгосон уу?

СЕХ-оос нөхөн сонгуулийн зардлын төсвийг үндэслэлтэй тооцон төлөвлөж, хуваарилсан байна.

СЕХ-ны 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 3/172 дугаар албан бичгээр Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороонд 6,740.0 мянган төгрөгийн, 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 3/217 дугаар албан бичгээр 11,811.0 мянган төгрөгийн, 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 3/236 дугаар албан бичгээр 28,750 мянган төгрөг зэрэг нийт **47,301.0** мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн Сонгуулийн хороонд хуваарилагдсан төсвийн зардлын санхүүжилтийг нэр төрлөөр нь харуулбал

Хүснэгт 1 /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр төрөл	Санхүүжилтийн хуваарь			
		2023.04.28 №3/172	2023.06.05 №3/217	2023.06.12 №3/236	Нийт
1	Маягт хэвлүүлэх зардал	150.0			150.0
2	Үнэмлэх хэвлэх зардал	150.0			150.0
3	Сонгуулийн хорооны сургалтын зардал	450.0			450.0
4	МТБ, даамлын сургалтын зардал	60.0			60.0
5	Бичиг хэргийн зардал	900.0			900.0
6	Шуудан, холбооны зардал	1,050.0			1,050.0
7	Унааны зардал	3,080.0	420.0		3,500.0
8	Санал авах байр, бэлтгэх зардал	900.0			900.0
9	Сурталчилгааны зардал		1,000.0		1,000.0
10	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх, унаа томилолт		5,854.0		5,854.0
11	Мэдээ дамжуулах шуурхай ажлын МТБ-ийн зардал		170.0		170.0
12	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/		360.0		360.0
13	Унааны зардал /Туршилтын болон санал авах өдрийн мэдээ дамжуулах/		315.0		315.0
14	Томилолтын зардал		2,192.0		2,192.0
15	Болзошгүй зардал		1,500.0		1,500.0
16	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал			24,000.0	24,000.0
17	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал			3,600.0	3,600.0
18	Саналын хуудас устгах зардал			1,150.0	1,150.0
Бүгд дүн		6,740.0	11,811.0	28,750.0	47,301.0

УБЕГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/1003 дугаар тушаалаар аймгийн УБХ-т 6,714.0 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна.

Аймгийн УБХ-т хуваарилагдсан төсөв, санхүүжилт

Хүснэгт 2 /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Зардлын нэр төрөл				Нийт дүн
		Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал	Бичиг хэргийн зардал	Унааны зардал	Томилолтын зардал	
1	Сэлэнгэ аймаг Улсын бүртгэлийн хэлтэс	3,150.0	438.0	982.0	2,144.0	6,714.0

1.2 Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын Сонгуулийн хороодын зардлыг үндэслэлтэй төлөвлөж хуваарилсан уу?

Сумдын Сонгуулийн хороодын зардлыг СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв, хуваарилах, зарцуулах, талан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам” болон СЕХ-ны 2023 оны 3/172, 3/217, 3/236 дугаар албан бичгүүдийн хавсралтаар ирүүлсэн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбарыг баримтлан аймгийн Сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороодод **27,320.0** мянган төгрөгийн төсвийг хуваарилсан байна. Сумдын Сонгуулийн хороодод хуваарилсан төсвийг эдийн засгийн ангиллаар харуулбал:

**Сумдын сонгуулийн хороонд хуваарилагдсан
төсөв, санхүүжилт**

Хүснэгт 3 /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр төрөл	Сумдын санхүүжилт		
		Баруунбүрэн	Сүхбаатар	Нийт
1	Үнэмлэх хэвлэх зардал	50.0		50.0
2	Бичиг хэргийн зардал	250.0	350.0	600.0
3	Шуудан, холбооны зардал	300.0	450.0	750.0
4	Унааны зардал	790.0	540.0	1,330.0
5	Санал авах байр, бэлтгэх зардал	300.0	600.0	900.0
6	Сурталчилгааны зардал	300.0	300.0	600.0
7	Саналын хуудас, ИСР төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх, унаа томилолт	780.0	50.0	830.0
8	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	120.0	240.0	360.0
9	Болзошгүй зардал	100.0	200.0	300.0
10	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал	8,400.0	13,200.0	21,600.0
Бүгд дүн		11,390.0	15,930.0	27,320.0

Сонгуулийн зардлын төсвийг үндэслэлтэй тооцон хуваарилсан тул төсөвт зохицуулалт хийгдээгүй байна.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ҮР АШИГТАЙ ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН УУ?

Орон нутгийн нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах нийт зардлын 15.8 хувийг хэмнэж, зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

2.1 Аймаг, сумын Сонгуулийн хороод хуваарилагдсан санхүүжилтийг зориулалтын дагуу, үр ашигтай хэмнэлттэй зарцуулсан уу?

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийн хэмнэлт 7,462.3 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

СЕХ-ноос Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хорооны төсвийг нийт **47,301.0** мянган төгрөгөөр баталж, хуваарилснаас **39,838.7** мянган төгрөгийг зарцуулж, төсвийн хэмнэлт болох **7,462.3** мянган төгрөгийг СЕХ-ны 100900022001 дугаар дансанд татан төвлөрүүлсэн байна.

Аймаг, сумдын Сонгуулийн хороодын батлагдсан төсөв, гүйцэтгэл

Хүснэгт 4 /мянган төгрөгөөр/

№	Сонгуулийн хороодын байршил	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт
1	Аймгийн Сонгуулийн хороо	19,981.00	12,518.70	7,462.30
2	Баруунбүрэн сумын Сонгуулийн хороо	11,390.00	11,390.00	0.00
3	Сүхбаатар сумын Сонгуулийн хороо	15,930.00	15,930.00	0.00
Нийт дүн		47,301.00	39,838.70	7,462.30

Орон нутгийн нөхөн сонгуулийн батлагдсан төсвийг үр ашигтай хэмнэлтэй зарцуулахад өмнөх сонгуулийн зардлын тайланд өгсөн аудитын зөвлөмж, Төрийн хэмнэлтийн тухай хууль, СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ыг баримтлан ажилласнаар сонгуулийн хорооны үйл ажиллагааны зардлыг 7,462.3 мянган төгрөгөөр хэмнэхэд дараах зардлууд голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Унааны зардлыг 1,315.0 мянган төгрөгөөр,
- Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх, унаа томилолтын зардлыг 3,324.0 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл дамжуулах шуурхай ажлын зардлыг 170.0 мянган төгрөгөөр,
- Томилолтын зардлыг 1,130.0 мянган төгрөгөөр,
- Болзошгүй зардлыг 1,112.4 мянган төгрөгөөр
- Сургалтын зардлыг 60.9 мянган төгрөгөөр
- Үнэмлэх хэвлэх зардлыг 100.0 мянган төгрөгөөр,
- Саналын хуудас устгах зардлыг 250.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

2.2 Сонгуулийн зардлын зарцуулалт, гүйцэтгэлийг бодитой тайлагнасан уу?

Зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтад үндэслэн журмын дагуу бодитоор тайлагнасан байна.

Аймаг, сумдын Сонгуулийн хороод нь сонгуулийн зардлын гүйцэтгэлийг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв тайлагнасан байна.

Аймгийн Сонгуулийн хорооны нэгтгэж, тайлагнасан төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг зардлын эдийн засгийн ангиллаар харуулбал:

Сонгуулийн зардлын гүйцэтгэл

Хүснэгт 5 /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр төрөл	Санхүүжилт
---	-------------------	------------

		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт	Хувь
1	Маягт хэвлүүлэх зардал	150.0	150.0	-	100.0
2	Үнэмлэх хэвлэх зардал	150.0	50.0	100.0	33.3
3	Сонгуулийн хорооны сургалтын зардал	450.0	449.1	0.9	99.8
4	МТБ, даамлын сургалтын зардал	60.0	-	60.0	-
5	Бичиг хэргийн зардал	900.0	900.0	-	100.0
6	Шуудан, холбооны зардал	1,050.0	1,050.0	-	100.0
7	Унааны зардал	3,500.0	2,250.0	1,250.0	64.3
8	Санал авах байр, бэлтгэх зардал	900.0	900.0	-	100.0
9	Сурталчилгааны зардал	1,000.0	1,000.0	-	100.0
10	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх, унаа томилолт	5,854.0	2,530.0	3,324.0	43.2
11	Мэдээ дамжуулах шуурхай ажлын МТБ-ийн зардал	170.0	-	170.0	-
12	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	360.0	360.0	-	100.0
13	Унааны зардал /Туршилтын болон санал авах өдрийн мэдээ дамжуулах/	315.0	250.0	65.0	79.4
14	Томилолтын зардал	2,192.0	1,062.0	1,130.0	48.4
15	Болзошгүй зардал	1,500.0	387.6	1,112.4	25.8
16	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал	24,000.0	24,000.0	-	100.0
17	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	3,600.0	3,600.0	-	100.0
18	Саналын хуудас устгах зардал	1,150.0	900.0	250.0	78.3
Бүгд дүн		47,301.0	39,838.7	7,462.3	84.2

УБЕГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/1003 дугаар тушаалаар аймгийн УБХ-т 6,714.0 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсныг тус хэлтсийн нэмэлт санхүүжилтийн 100130012420 дугаар дансанд төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

УБХ-т олгосон санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт 6 /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр төрөл	Батлагдсан төсөв, гүйцэтгэл			Хувь
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт	
1	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал	3,150.0	3,145.6	4.4	99.9
2	Бичиг хэргийн зардал	438.0		438.0	-
3	Унааны зардал	982.0	445.0	537.0	45.3
4	Томилолтын зардал	2,144.0	964.0	1,180.0	45.0
Бүгд дүн		6,714.0	4,554.6	2,159.4	67.8

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь нөхөн сонгуулийн батлагдсан төсвөөс 32.2 хувийг хэмнэж, зарцуулагдаагүй үлдэгдэл 2,159.4 мянган төгрөгийг УБЕГ-ын нэмэлт санхүүжилтийн 100900012419 дүгээр дансанд төвлөрүүлсэн байна.

Аудитын дүгнэлт

Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Орон нутгийн нөхөн сонгуулийн зардлыг холбогдох хууль, эрхийн актын дагуу хуваарилсан байна.
- СЕХ-оос нөхөн сонгуулийн зардлын төсвийг үндэслэлтэй тооцон төлөвлөж, хуваарилсан байна
- Сумдын Сонгуулийн хороодын зардлыг СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан "Сонгуулийн төсөв, хуваарилах, зарцуулах, талан гаргах, хяналт тавих журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.
- Аймгийн Сонгуулийн хорооноос орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулах нийт зардлын **15.8** хувийг хэмнэж, зарцуулагдаагүй үлдэгдэл **7,462.3** мянган төгрөгийн үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.
- Аймаг, сумдын Сонгуулийн хороо нь сонгуулийн зардлын гүйцэтгэлийг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв тайлагнасан байна.
- УБХ нь хуваарилагдан ирсэн төсвийг **32.2** хувиар хэмнэж **2,159.4** мянган төгрөгийн үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.
- Өмнөх аудитаар аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласнаар зөрчил дутагдал гаргаагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Т.ОДСҮРЭН

Аймгийн Сонгуулийн хорооноос ирүүлсэн санал, тайлбар



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 7036-3966

2023.07.05 № 15
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин
сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт,
зарцуулалт, гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн
төсөлтэй танилцлаа санал тайлбаргүй болно.

АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ
ДАРГА Ө.СУВДАА





**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС**

Нутгийн захиргааны 3 дугаар байр, 2 дугаар баг,
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081
Утас: 7036 3009, Факс: (976) 7036 3019,
Цахим шуудан: selenge@burtgel.gov.mn,
Цахим хуудас: www.selenge.burtgel.gov.mn

2023.07.05 № 686

танай _____-ны № _____-т

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин
сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт,
зарцуулалт, гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн
төсөлтэй танилцлаа санал тайлбаргүй болно.

ДАРГА

Б.САРАНЧИМЭГ



0000000000



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар A/15


Сүхбаатар сум

┌ Аудитын тайлан баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн ИТХ-ын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл" сэдэвт аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг open.audit.mn сайтаар нийтэд мэдээлэхийг аудитор /О.Анхбаяр/-т даалгасугай.
3. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитор /Т.Одсүрэн/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Батмөнх/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

018010044